

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2025/156/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өлгий хот 2025 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn “Анализ старт аудит” ХХК-ийн захирал: Н.Энхтуяа Утас:99075818 Цахим хаяг:asaudit.mn@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgiu@audit.gov.mn

### БАЯН ӨЛГИЙ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН САЙХАН БАГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.АМАНБОЛ ТАНАА

2025.02.21 № 86  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Сайхан багийн ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Булган сумын Сайхан багийн ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 817.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 769.2 сая төгрөг зарцуулж, 94.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

### **Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>117,615,762.64</u></b>	<b><u>147,455,121.82</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	62,950,494.45	81,218,796.72
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	62,950,494.45	81,218,796.72
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	62,950,494.45	81,218,796.72
31211	Төрийн сангийн харилцах	62,940,494.45	81,208,796.72
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	10,000.00	10,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	54,665,268.19	66,236,325.10
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	500,000.00	500,000.00
35110	Тусгай зориулалттай материал	500,000.00	500,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>53,343,268.19</b>	<b>64,914,325.10</b>
35410	Бичиг хэргийн материал	1,020,900.00	1,915,961.32
35420	Аж ахуйн материал	28,799,750.50	33,144,856.50
35440	Түлш, шатах тослох материал	5,988,380.10	14,767,984.50
35460	Хүнсний материал	16,797,737.59	14,349,022.78
35470	Бусад хангамжийн материал	736,500.00	736,500.00
35600	Мал амьтад	822,000.00	822,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,195,798,689.40</u></b>	<b><u>2,582,618,464.53</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,195,798,689.40</b>	<b>2,582,618,464.53</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,152,473,450.40</b>	<b>2,539,767,638.57</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,284,674,912.24	2,594,990,361.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	(198,949,589.61)	(242,323,613.13)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	89,478,353.00	214,642,498.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(38,071,668.98)	(61,063,058.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,658,409.41	58,848,409.41
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,954,165.66)	(28,371,925.50)
39217	Ном	2,637,200.00	3,044,967.00

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	43,325,239.00	42,850,825.96
39301	Програм хангамж	1,973,239.00	1,973,239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(550,000.00)	(1,024,413.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,902,000.00	41,902,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,313,414,452.04</u></b>	<b><u>2,730,073,586.35</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>209,310.00</u></b>	<b><u>14,077,500.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	209,310.00	14,077,500.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	209,310.00	14,077,500.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	209,310.00	14,077,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	209,310.00	14,077,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,313,205,142.04</u></b>	<b><u>2,715,996,086.35</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,313,205,142.04	2,715,996,086.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	135,116,466.00	135,116,466.00
51101	Өмч: - төрийн	135,116,466.00	135,116,466.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,982,159,611.00	2,384,950,555.31
51210	Өмнөх үеийн үр дүн	1,982,159,611.00	1,982,159,611.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	402,790,944.31
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	195,929,065.04	195,929,065.04
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,313,414,452.04</u></b>	<b><u>2,730,073,586.35</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>508,587,938.00</b>	<b>1,055,575,718.32</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>438,836,918.32</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	438,836,918.32
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	434,186,918.32
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		434,186,918.32
120009	Бусад орлого	-	4,650,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>508,587,938.00</b>	<b>616,738,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>457,745,938.00</b>	<b>568,436,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	433,170,700.00	568,436,800.00

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	24,575,238.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	50,842,000.00	48,302,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,842,000.00	48,302,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>502,898,908.41</b>	<b>652,784,774.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>502,898,908.41</b>	<b>652,784,774.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	471,403,437.01	648,684,000.41
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	290,055,096.55	435,551,918.55
210101	Үндсэн цалин	213,613,588.30	262,428,357.12
210102	Нэмэгдэл	63,790,960.75	156,426,333.98
210104	Урамшуулал	12,650,547.50	16,697,227.45
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,570,000.00	67,765,816.00
210201	Тэтгэврийн даатгал	28,395,100.00	46,223,086.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,340,800.00	5,438,010.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,672,900.00	4,350,408.00
210204	Ажилгүйдлийн даатгал	668,100.00	1,087,602.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,493,100.00	10,666,710.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	49,228,614.00	38,364,300.00
210301	Гэрэл, цахилгаан	1,871,334.00	4,669,000.00
210302	Түлш, халаалт	47,357,280.00	33,695,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	18,480,946.60	21,628,691.21
210502	Хоол, хүнс	18,480,946.60	21,628,691.21
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	900,000.00	2,063,838.70
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	900,000.00	2,063,838.70
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	71,168,779.86	83,309,435.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,857,680.00	11,379,850.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		672,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,311,099.86	71,257,585.87
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	31,495,471.40	4,100,773.60
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	9,467,905.40	3,687,673.60
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,467,905.40	1,496,373.60
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,191,300.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	22,027,566.00	413,100.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,027,566.00	413,100.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>5,689,029.59</b>	<b>402,790,944.31</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>5,689,029.59</b>	<b>402,790,944.31</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>484,012,700.00</b>	<b>621,388,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>4,650,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	4,650,000.00
120009	Бусад орлого		4,650,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>484,012,700.00</b>	<b>616,738,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	433,170,700.00	568,436,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	433,170,700.00	568,436,800.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	50,842,000.00	48,302,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,842,000.00	48,302,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>421,683,376.55</b>	<b>588,742,997.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>421,683,376.55</b>	<b>588,742,997.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>389,019,410.55</b>	<b>581,235,697.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	290,429,096.55	447,132,144.55
210101	Үндсэн цалин	207,148,129.30	274,008,583.12
210102	Нэмэгдэл	69,626,588.02	156,426,333.98
210104	Урамшуулал	13,654,379.23	16,697,227.45
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	41,000,500.00	56,394,900.00
210201	Тэтгэврийн даатгал	28,395,100.00	38,348,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,340,800.00	4,511,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,672,900.00	2,255,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	663,600.00	2,255,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,928,100.00	9,023,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	28,464,434.00	47,059,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,471,334.00	2,793,000.00
210302	Түлш, халаалт	25,993,100.00	44,266,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	13,949,050.00	15,943,350.00
210502	Хоол, хүнс	13,949,050.00	15,943,350.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	350,000.00	829,900.00

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	350,000.00	829,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,849,200.00</b>	<b>2,367,213.18</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	728,600.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,120,600.00	2,367,213.18
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,977,130.00</b>	<b>11,509,190.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,296,130.00	10,132,540.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,681,000.00	1,376,650.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,663,966.00</b>	<b>7,507,300.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,636,400.00</b>	<b>7,094,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,636,400.00	4,733,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,361,200.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>22,027,566.00</b>	<b>413,100.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,027,566.00	413,100.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>62,329,323.45</b>	<b>32,645,802.27</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,347,000.00</b>	<b>14,377,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,347,000.00</b>	<b>14,377,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>15,347,000.00</b>	<b>14,377,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,347,000.00	14,377,500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(15,347,000.00)</b>	<b>(14,377,500.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>46,982,323.45</b>	<b>18,268,302.27</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>16,537,671.00</b>	<b>62,950,494.45</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>62,950,494.45</b>	<b>81,218,796.72</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	135,116,466.00	195,929,065.04	1,973,711,151.09	2,304,756,682.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	135,116,466.00	195,929,065.04	1,973,711,151.09	2,304,756,682.13
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн			5,689,029.59	5,689,029.59
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	850,148,776.35	195,929,065.04	234,751,616.35	1,280,829,457.74
D01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	850,148,776.35	195,929,065.04	234,751,616.35	1,280,829,457.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	135,116,466.00	195,929,065.04	1,982,159,611.00	2,313,205,142.04
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			402,790,944.31	402,790,944.31
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	850,148,776.35	876,300,087.94	2,384,950,555.31	2,715,996,086.35

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>501,440,400.00</b>	<b>411,522,310.55</b>	<b>83,301,600.00</b>	<b>602,707,393.73</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	501,440,400.00	411,522,310.55	683,301,600.00	602,707,393.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	485,325,100.00	400,885,910.55	667,318,900.00	595,613,193.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	338,034,100.00	290,429,096.55	486,506,600.00	447,132,140.55
210101	Үндсэн цалин	230,513,900.00	207,148,129.30	333,028,500.00	274,008,583.12
210102	Нэмэгдэл	93,503,200.00	70,630,419.75	147,940,800.00	156,426,333.98
210104	Урамшуулал	14,017,000.00	12,650,547.50	5,537,300.00	16,697,223.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,254,400.00	41,570,000.00	60,813,300.00	56,394,900.00
210201	Тэтгэврийн даатгал	28,733,100.00	28,395,500.00	41,353,100.00	38,348,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,380,300.00	3,340,700.00	4,865,000.00	4,511,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,704,300.00	2,672,600.00	2,432,500.00	2,255,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	676,100.00	668,300.00	2,432,500.00	2,255,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,760,600.00	6,492,900.00	9,730,200.00	9,023,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,793,000.00	28,464,434.00	50,793,000.00	47,059,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,793,000.00	2,471,334.00	2,793,000.00	2,793,000.00
210302	Түлш, халаалт	48,000,000.00	25,993,100.00	48,000,000.00	44,266,000.00
2105	Нормативт зардал	22,699,600.00	13,949,050.00	34,200,400.00	15,943,350.00
210502	Хоол, хүнс	22699600	13949050	34,200,400.00	15,943,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	350,000.00	350,000.00	850,000.00	829,900.00
210604	Урсгал засвар	350,000.00	350,000.00	850,000.00	829,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,470,600.00	1,849,200.00	3,590,200.00	2,367,213.18

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,350,000.00	728,600.00	21,400.0	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,120,600.00	1,120,600.00	3,568,800.0	2,367,213.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,723,400.0	24,274,130.0	30,565,400.0	25,886,690.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,042,400.00	22,593,130.00	29,112,300.0	24,510,040.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,681,000.00	1,681,000.00	1,453,100.0	1,376,650.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,115,300.0	10,636,400.0	15,982,700.0	7,094,200.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,115,300.0	10,636,400.0	15,982,700.0	7,094,200.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,115,300.0	10,636,400.0	13,621,500.0	4,733,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			2,361,200.0	2,361,200.0
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>58,942,000.0</b>	<b>28,814,434.0</b>	<b>683,301,600.0</b>	<b>620,975,700.00</b>
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	568,436,800.0	568,436,800.0
131001	Улсын төсвөөс санхүүжих			568,436,800.0	568,436,800.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	50,842,000.0	28,814,434.0	51,643,000.0	47,888,900.0
132001	Орон нутгийн төсвөөс	50,842,000.00	28,814,434.00	51,643,000.0	47,888,900.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,100,000.00	-	63,221,800.00	4,650,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,350,000.00			
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,750,000.00		5,350,000.00	4,650,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-		57,871,800.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		16,537,671.00		62,950,494.45
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		62,950,494.45		81,208,796.72

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага юм. Тус сургууль нь 2024 онд “Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын Ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг зарим хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлтүүд орсон байна.

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас санхүүгийн баримтын шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нээгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сургуулийн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг бөгөөд уг баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 416.6 сая төгрөгөөр буюу 18.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	62,950.49	81,218.80	18,268.30
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	54,665.27	66,236.33	11,571.06
Үндсэн хөрөнгө	2,195,798.69	2,582,618.46	386,819.78
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,313,414.45</b>	<b>2,730,073.59</b>	<b>416,659.13</b>
Өр төлбөр	209.31	14,077.50	13,868.19
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,313,205.14	2,715,996.09	402,790.94
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,313,414.45</b>	<b>2,730,073.59</b>	<b>416,659.13</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө оны эцэст 81.2 сая төгрөг үлдэгдэлтэй гарч, оны эхнээс 18.3 сая төгрөгөөр өссөн байна. Мөнгөн хөрөнгө үлдэгдлийн 81,208.8 мянган төгрөг нь төсвийн санхүүжилтийн, 10.0 мянган төгрөг нь өмнөх оны нэмэлт санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бараа материал данс оны эцэст 66.2 сая төгрөг болж, оны эхнээс 11.6 сая төгрөгөөр өссөн байна. Хүнсний материал 14.4 сая төгрөгийн, түлш 14.7 сая төгрөгийн, аж ахуйн материал 33.1 сая төгрөгийн, бичиг хэрэг 1.9 сая, тусгай зориулалтын материал 0.5 сая, бусад хангамжийн материал 0.7 сая, мал амьтад 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,582.6 сая төгрөг болж, 386.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 28.4 сая төгрөгийн хөрөнгө /булэн мөнгөөр авсан 14.3 сая төгрөг, зээлээр авсан 14.1 сая төгрөг/ худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 429.6 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд 68.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,715.9 сая төгрөг болж, 402.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 402.8 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сургуулийн 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 563.8 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 50.2 сая төгрөг, нийт зарлагыг 614.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас сургуулийн 2024 оны хувьсах зардлын төсвийг 551.8 сая төгрөгөөр хянаж, 12.0 сая төгрөгөөр бууруулан баталсан ба төсвийн тодотголоор 79.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 631.7 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 51.1 сая төгрөгөөр хянаж, 0.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан ба тодотголоор 0.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 51.6 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 631.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 51.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, нийтдээ 683.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 568.4 сая, орон нутгийн төсвөөс 47.9 сая, нийт 616.3 сая төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагаанаас 4.6 сая, оны эхний үлдэгдлээс 57.9 сая төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 602.7 сая төгрөг болж, 88.2 хувийн биелэлттэй, 81.2 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр арга хэмжээний нэр	Код	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Байр ашиглалтын үйлчилгээ	80226	363,300.00	182,800.00	-180,500.00	50.32
2	Хүүхэд хамгаалал	80233	382,800.00	290,000.00	-92,800.00	75.76
3	Сургалт семинар	80312	242,200.00	136,000.00	-106,200.00	56.15
4	Эрүүл мэндийг дэмжих	81605	363,300.00	0.00	-363,300.00	0.00

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5	Үдийн цай хөтөлбөр	81801	13,621,500.00	4,733,000.00	-8,888,500.00	34.75
6	Дотуур байрны үйлчилгээ	81806	161,567,000.00	139,226,294.55	-22,340,705.45	86.17
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	81816	14,197,300.00	14,077,500.00	-119,800.00	99.16
8	Боловсролын байгууллагын багш ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	81823	1,089,800.00	760,000.00	-329,800.00	69.74
9	Боловсролын стандарт сургалтын үйл ажиллагаа	81834	424,981,900.00	385,103,884.70	-39,878,015.30	90.62
10	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	81835	8,451,000.00	8,451,000.00	0.00	100.00
11	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	81844	5,629,500.00	1,554,640.00	-4,074,860.00	27.62
12	Сурах бичгийн түрээс	81848	21,400.00	0.00	-21,400.00	0.00
13	Сургалтын нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	81875	747,600.00	303,374.48	-444,225.52	40.58
	<b>Улсын төсвийн санхүүжилтийн дүн</b>		<b>631,658,600.00</b>	<b>554,818,493.73</b>	<b>-76,840,106.30</b>	<b>87.84</b>
	Нийтлэг үйлчилгээ ОН		51,643,000.00	47,888,900.00	-3,754,100.00	92.73
	<b>Орон нутгийн төсвийн санхүүжилтийн дүн</b>		<b>51,643,000.00</b>	<b>47,888,900.00</b>	<b>-3,754,100.00</b>	<b>92.73</b>
	<b>Нийт дүн</b>		<b>683,301,600.00</b>	<b>602,707,393.73</b>	<b>-80,594,206.30</b>	<b>88.21</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургууль нь Ахмадын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан ажиллуулах журам”-ыг хэрэгжүүлээгүй буюу ахмадын сан байгуулж ажиллаагүй байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталж ажиллаагүй байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас 2.4 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын дансаар 11.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын 2024 оны орон тооны судалгааг гаргуулан авч хянаж үзэхэд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны жишиг орон тоог баримтлан ажиллажээ.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Сургууль нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуульд Pearson /5 дугаар ангийн англи хэл/, Eduten /1-5 дугаар ангийн математик/ хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургууль нь 2024 онд 71.4 сая төгрөгийн бараа материал, 14.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Анализ старт аудит” ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, шинжээч Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг компанийн захирал Н.Энхтуяа, дараагийн шатны хяналтыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Анализ старт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Булган сумын Сайхан багийн ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 500.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай /*өмнөх оноос улсын төсвийн санхүүжилт өссөн*/ гэж үзсэн учир 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 609.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлэхэд алдаа, зөрчил илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 6 /Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт 2 удаа, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал 2 удаа, Байгууллагын батлагдсан төсөв, Дараа жилийн төсвийн төсөл/ мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илрэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийхэд дансны код сонголт, бичилт, ангилалтай холбоотой 454.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгч, үйлчлүүлэгч байгууллагад Асуудлын бүртгэлээр хүргүүлсэн ба 454.9 сая төгрөгийн алдааг залруулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах зөвлөмж хэрэгжээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 58.2 сая төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөнийг давтан шалгаж үзэхэд хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	58,219.3	1	58,219.3	100.0
Нийт дүн	1	58,219.3	1	58,219.3	100.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авалтын төлөвлөлт, хэрэгжилт, цалингийн нэмэгдлүүдийн асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзэв.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 70.9 сая төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд 70.9 сая төгрөгийн залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд: *Залруулсан алдаа:*

- Бараа материалын оны эхний үлдэгдлийг 0.016 сая төгрөгөөр бууруулсан,
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 42.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- Худалдан авсан 28.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Үндсэн хөрөнгийн тодруулгад үнэ төлбөргүй хүлээн авснаар бүртгэснийг тус тус залруулав.

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

Бичигдээгүй.

### **5.2 Албан шаардлага**

Бичигдээгүй.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## ***1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой асуудал***

### **1.1 Илрүүлэлт:**

Сургууль нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /хоол хүнс 34.2 сая төгрөг, үндсэн хөрөнгө 28.4 сая төгрөг г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.", 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана." гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;

## ***2. Бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

### **2.1 Илрүүлэлт:**

Бараа материал дансанд 2017 оноос 822.0 мянган төгрөгийн малын хашааг мал амьтад гэж дансны ангилал буруу хийсэн, багцлан бүртгэсэн, нэр тодорхойгүй бараа материал байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **2.2 Өгсөн зөвлөмж:**

Бараа материалыг багцлан бүртгэсэн, дансны ангилалыг зөв хийгээгүй алдаа дутагдлыг засах, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх.

### 3. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

#### 3.1 Илрүүлэлт:

Худалдан авсан 600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зардалд бичсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 3.2 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг зардалд бүртгэсэн зөрчлийг арилгаж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын оны эхний үлдэгдлийг бууруулсан	1	16.4			1	16.4	1	16.4				
Элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн.	1	42,800.0			1	42,800.0	1	42,800.0				
Худалдан үндсэн хөрөнгийг Үндсэн хөрөнгийн тодруулгад үнэ төлбөргүй хүлээн авснаар бүртгэсэн.	1	28,155.0			1	28,155.0	1	28,155.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>70,971.4</b>			<b>3</b>	<b>70,971.4</b>	<b>3</b>	<b>70,971.4</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт ны тоо	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, тайлагнаагүй.	1	0					1	0				
Бараа материалын ангилал, бүртгэлтэй холбоотой	1	822.0					1	822.0				
Худалдан авсан үндсэн хөрөнгийг зардалд бичсэн байна.	1	600.0					1	600.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,422.0</b>					<b>3</b>	<b>1,422.0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн								

Булган сумын Сайхан багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан